

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2020 ОНЫ 01 САРЫН 08-НИЙ ӨДРИЙН 03 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН “ӨВЛИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙН 2020-2023 ОНЫ ТАЙЛАН:

| д/д   | Хөтөлбөрийн зорилт  | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин /2019 он/  | Зорилтот түвшин /2023 он/                                    | Хүрсэн түвшин   | Биелэлт -ийн хувь |
|---|---|---|---|--|---|-------------------|
| <b>5.1. Өвлийн спорт болон нийтийн биеийн тамирыг нийтэд сурталчлах, чийрэгжүүлэлтийн зөв дадал олгох, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх;</b> |   |   |   |  |   |                   |
| 1   | 5.1.1.Өвлийн спортын секц дугуйлангуудын төрөл, тоог нэмэгдүүлэх;   | Өвлийн спортын төрлийн спорт холбоод, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх | Спорт холбоод 2, Хичээллэгчид 1400  | Спортын холбоо 4, хичээллэгчдийн тоог 2000-д хүргэсэн байна. | Аймгийн хэмжээнд өвлийн спортын 5 холбоо, 1 клуб тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Сархиа цанын бааз, Орос 19-р сургуулийн хоккейн талбай, “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-ийн мөсөн талбайд снөүбоард, уулын цана, гүйлтийн цана, тэшүүр, хоккейн спортоор 2500 гаруй иргэд хичээллэж байна. Үүнээс:өвлийн спортын 6 төрлөөр 532 иргэн тамирчид бэлтгэл сургуулилттай тогтмол хийдэг. | 100               |
| 2   | 5.1.2.Үндэсний спортын төрөл болох мөсний шагай, мөсөн сурын спортыг хөгжүүлэх, шинэ залуу тамирчдыг бэлтгэх; | Шинэ залуу тамирчдыг бэлтгэсэн байх                                   | Мөсний шагайн харваа 63 тамирчин үүнээс өсвөрийн тамирчин 3, Мөсний сур-0 | Залуу тамирчдыг 25-иар нэмэгдүүлнэ                           | Үндэсний спортын төрөл болох мөсний шагай, мөсөн сурын спортыг хөгжүүлж тамирчдын тоог 286-д хүргэснээс шинэ залуу тамирчдыг 55-аар нэмэгдүүлж ажилласан.<br>Мөсний шагайн харвааны тамирчдын тоо 165, Үүнээс: насанд хүрэгч 67, залуу тамирчин-56, өсвөр үе-42;<br>Мөсний сур харвааны тамирчдын тоо 121, Үүнээс: насанд хүрэгч -75 залуу тамирчин 30 өсвөр үе-16;   | 100               |
| 3   | 5.1.3.Өвлийн спортын чиглэлээр улсын болон бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон                           | Тэмцээнийг амжилттай зохион байгуулсан байх                           | 2   | 4  | Улсын хэмжээний спортын өвлийн 2 наадмын хүрээнд тус бүр 6 төрлөөр, бүсийн тэмцээнийг 3 төрлөөр аймагтаа тус тус зохион байгуулсан.Үүнд:<br>-Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг снөүбоард, уулын цана, гүйлтийн цана, гүйлтийн тэшүүр,  | 100               |

|   |   |  |                |                |  |      |
|---|---|--|----------------|----------------|--|------|
|   | нутагтаа зохион байгуулах, оролцох  |  |                |                | <p>шорт трек, хоккейн тэмцээнийг тус бүр 6 төрлөөр аймагтаа амжилттай зохион байгуулсан. Тус наадмуудад 13 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. Орхон аймгаас бүх ард түмний спортын наадамд 6 төрөлд 49 тамирчин оролцож багийн дүнгээр 2-р байр эзэлж мөнгөн медаль өргөмжлөл цом хүртсэн бол хүүхдийн спортын өвлийн VII наадамд 5 төрлөөр 54 тамирчин оролцсоноос Уулын цанын төрөлд байгууллагын дүнгээр 1-р байр буюу алтан медаль, гүйлтийн цанын сонгомолын охидын төрөлд 2-р байр буюу мөнгөн медаль, гүйлтийн цанын тэшилтийн төрөлд байгууллагын дүнгээр 3-р байр буюу хүрэл медаль, шайбтай хоккейн баг 1-р байр буюу алтан медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн. Наадмын шилдэг спортын дунд сургуулиар спортын төрөлжсөн сургалттай "Ирээдүйн-Одод" дунд сургууль шалгарсан амжилтыг тус тус үзүүлсэн.</p> <p>-Улаанбаатар хотод хоккейн төрлөөр насанд хүрэгч, өсвөр үеийн шигшээ баг 5 тэмцээнд, мөсний шагайн харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнд, гүйлтийн цанын тамирчид Булган аймагт "Анхдагчийн цом" тэмцээнд тус тус оролцсон.</p> |      |
| 4 | 5.1.4. Аймаг, орон нутгаас төрөн гарсан ахмад багш болон шилдэг тамирчдаа алдаршуулах, сургалт зохион явуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах; | Тамирчдыг алдаршуулах, сурталчлах ажил хийгдсэн байх | Сурталчилга -1 | Сурталчилгаа-5 | <p>-Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмын хүрээнд мэдээ мэдээллийн сурталчилгааг <a href="http://www.erdenet.mn">www.erdenet.mn</a>, <a href="http://www.ubn.mn">www.ubn.mn</a>, <a href="http://www.gereg.mn">www.gereg.mn</a>, <a href="http://www.gogo.mn">www.gogo.mn</a>, <a href="http://www.zaluucom.mn">www.zaluucom.mn</a> вэб сайтуудад 19 мэдээ сурвалжлага, орон нутгийн "Арбис медиа" ХХК, "Колор фильмс" студи 69 удаа мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Мөн спортын 2 наадмын хүрээнд зохион байгуулагдсан 6 төрлийн тэмцээнийг 4 байршлаас МҮОНТ-н MNB спорт сувагийн 18 хүнтэй 2 багийг 7 өдрийн турш 2 авто машинтай ажиллуулж, орон нутгаас анх удаа шууд дамжуулалтыг улс орон даяар хийлээ. Шууд дамжуулалтаар өвлийн спортын тэмцээн уралдаан,</p>  | 100% |

|   |  |  |   |   |  |      |
|---|--|--|---|---|--|------|
|   |  |  |   |   | <p>дасгалжуулагч тамирчдыг ярилцлага мэдээ мэдээллийг үзүүлж, улс орон даяар сурталчилсан.</p> <p>Улсын төсвөөс 30,0 сая төгрөгийн мэдээлэл сурталчилгаанд зарцуулсан.</p>   |      |
| 5   | 5.1.5.Өвлийн спортын хувцас, хэрэглэл, материал оёдог, зардаг спорт барааны дэлгүүр, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг дэмжиж, хамтран ажиллах | Иргэн аж ахуйн нэгжийг дэмжин ажилласан байх                 | Спортын хувцасны оёдлын цех-2, Спортын хэрэгслийн дэлгүүр-2 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин ажилласан байх                      | <p>Наадмын өнгө бэлгэдлийг илэрхийлсэн малгай ороолтыг “Орхон хан сүлжмэл” ХХК-иар 200ш, наадмын бэлгэдэл арслан, галхүүг “Хамтдаа урлая клуб”-н эмэгтэйчүүдээр 300ш, наадмын логотой аяга, түлхүүрийн оосор, аяганы суурь 1265ш “Тод өнгө” ХХК-иар, гудамж зам талбайд наадмын өнгө логотой 800ш туг далбаа, 1500м2 анонс, сайн дурын ажилтны хантааз 90ш “Уран хас” ХХК, “Зөв хэвлэл” ХХК-уудтай хамтран ажиллаж хийлгэсэн.</p> <p>Улсын төсвөөс 80,5 сая төгрөгийн худалдан авалт хийж иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажилласан.</p> | 100% |
| 5.2.Аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах,оролцуулах нөхцөл бололцоогоор хангах; |  |  |   |   |  |      |
| 6   | 5.2.1.Жил бүр өвлийн спортын 3-4 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулж хэвших;                             | Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан байх | ААШТэмцээн 3 удаа /цана, хоккей, мөсөн шагай/               | ААШТ 6 удаа /цана, тэшүүр, шорт трек, хоккей, мөсөн шагай, мөсний сур харваа/ | “Эрдэнэт мөнгөн өвөл-2023” аяны хүрээнд уулын цанын снөүбоард, гүйлтийн тэшүүр, гүйлтийн цана, мөсөн шагай мөсний сур харвааны тэмцээнийг 2 насны ангиллаар зохион байгуулж 8 аймаг, 5 клубын нийт 350 тамирчин оролцсон.  | 100% |
| 7   | 5.2.2.Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бусад аймаг, сумын баг тамирчидтай хамтарсан туршлага   | Хамтарсан бэлтгэл сургуулилт хийсэн байх                     | 4   | 6   | Булган аймгийн “Анхдагчдын цом” нэрэмжит тэмцээнд гүйлтийн цанын төрөлд Орхон аймгаас насанд хүрэгч өсвөр үеийн ангилалд 16 тамирчин Орон нутгийн төсвөөс 2,0 мянган төгрөг, Цанын сэргэлтийн 20 тамирчин орон нутгийн төсвөөс 7,840.0 мянган төгрөг хоккейн өсвөрийн  | 100% |

|   |  |   |   |   |   |      |
|---|--|---|---|---|---|------|
|   | солилцох уулзалт,<br>нөхөрсөг тэмцээн<br>болон сэргэлтийн<br>бэлтгэлийг зохион<br>байгуулах;   |   |   |   | тамирчдын сэргэлтийн бэлтгэлд 1,860.0 мян төгрөгийг тус тус зарцуулсан.   |      |
| 8   | 5.2.3.Тамирчдын<br>залгамж халааг<br>бэлтгэх зорилгоор<br>төрөлжсөн сургалттай<br>спортын дунд<br>сургуульд жил бүр<br>цана, тэшүүрийн<br>тамирчдын элсэлт<br>авах                         | Цана,<br>тэшүүрийн<br>секц<br>дугуйланд<br>элсэлт<br>авсан байх | Цана-15<br>Тэшүүр-1                         | Цана-30<br>Тэшүүр-15                        | Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын<br>“Ирээдүйн-Одод” дунд сургууль 2023-2024 оны хичээлийн<br>жилд 6-12 ангийн нийт 7 бүлэгийн 168 сурагчдад<br>тэшүүрийн хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.<br>Биеийн тамир, спортын газарт гүйлтийн цанын секцэд 40,<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Спорт цогцолборт уулын цанын<br>секцэд 35 өсвөрийн тамирчин тус тус хичээллэж байна. | 70%  |
| 9   | 5.2.4.Дэлхий, тив,<br>олон улс, улсын<br>аварга шалгаруулах<br>тэмцээнд өндөр<br>амжилт гаргасан<br>тамирчдыг жил бүр<br>урамшуулах;   | Жил бүр<br>тамирчдад<br>урамшуулал<br>олгосон<br>байх           | -   | -   | Аймгийн Засаг даргын 2023 оны А/229 дүгээр захирамжаар<br>биатлоны ази тивийн аварга шалгаруулах тэмцээн,<br>гүйлтийн цана, мөсөн шагай, уулын цанын улсын аварга<br>шалгаруулах тэмцээнээс алт 4, мөнгө 5, хүрэл медаль 9<br>хүртсэн нийт 18 тамирчинд 1.285.0 мянган төгрөгийн<br>урамшуулал олгосон.   | 100% |
| <b>5.3.Орон нутагт өвлийн спортын мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах<br/>нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах.</b> |  |   |   |   |   |      |
| 10  | 5.3.1.Ерөнхий<br>боловсролын<br>сургуулиудад биеийн<br>тамирын багшийг<br>өвлийн спортын төрөл<br>хариуцуулж<br>ажиллуулах, богино<br>хугацааны сургалтаар<br>мэргэшүүлж,<br>чадваржуулах; | Сургалт<br>зохион<br>байгуулсан<br>байх                         | Сургалтад<br>хамрагдсан<br>багшийн<br>тоо-0 | Сургалтад<br>хамрагдах<br>багшийн<br>тоо-10 | Өвлийн спортын гүйлтийн цана, уулын цана, хоккейн<br>спортын төрлүүдээр нийт 6 удаагийн сургалтаар 35 биеийн<br>тамирын багш, дасгалжуулагч нарыг сургалтад<br>хамруулсан.  | 100% |

|    |  |                                    |                 |                 |  |      |
|----|--|------------------------------------|-----------------|-----------------|--|------|
| 11 | 5.3.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, спортын клуб, холбоодтой хамтран ажиллах;  | Хамтын ажиллагааг сайжруулсан байх | Спорт холбоод 2 | Спорт холбоод 4 | Аймгийн өвлийн спортын “Ирээдүйн хос мөртөн” цанын холбоо, “Мөсөн сур”, “Мөсөн шагай” “Хоккейн” холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан спортын өвлийн наадмыг зохион байгуулахад Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын улсын хороо, МҮОНТ-н MNB спорт суваг, Монголын хоккейн холбоо, Монголын тэшүүрийн холбоо, Монголын үндэсний “Цасан зам” цанын холбоод, орон нутгаас төрийн байгууллага 25, төрийн өмчит үйлдвэрийн газар 6, “Юнител ХХК” Ачит ихт” ХХК “Эрдэнэт хивс” ХХК, “Эрдмин” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд, худалдаа үйлчилгээ эрхлэгч 40 гаруй иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллалаа. Хамтын ажиллагааны хүрээнд тус 2 наадмыг зохион байгуулахад биеийн тамир спортын улсын хорооноос 275,0 сая төгрөг, томоохон аж ахуйн нэгжүүдээс 20,0 сая төгрөгийн хандив, орон нутгийн төсвөөс 60 сая төг нийт 355,0 сая төгрөг зарцуулж, 12 аймаг 7 дүүргээс 700 гаруй дасгалжуулагч, тамирчид, зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж зочид буудал, хоол үйлдвэрлэл, бэлэг дурсгал, хэвлэл мэдээлэл, бусад үйлчилгээний байгууллагуудад 650,0 сая гаруй төгрөгийн худалдан авалт хийгдэж, Орхон аймагт нийт 1,036.5 (тэрбум гучин зургаан сая) төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн. | 100% |
| 12 | 5.3.3.Өвлийн спортыг хөгжүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай, амжилттай ажиллаж байгаа багш дасгалжуулагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх; | Урамшуулал , дэмжлэг үзүүлсэн байх | -               | -               | Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмын зохион байгуулалтад хандив туслалцаа үзүүлсэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэт хивс”, “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Юнител” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд, хамтран ажилласан аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газрын хамт олонд батламжийг гардуулж алдаршуулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/229 дүгээр захирамжаар спортын өвлийн наадамд баг тамирчдыг бэлтгэн амжилттай оролцуулсан аймгийн “Хос мөртөн цанын холбоо”-г 400,0 мянган төгрөгөөр урамшуулсан. Мөн мөсний шагайн харвааны улсын аварга шалгаруулах  | 100% |

|  |  |  |                     |                      |   |      |
|--|--|--|---------------------|----------------------|---|------|
|  |  |  |                     |                      | тэмцээнд оролцох баг тамирчдад 774,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.   |      |
| 5.4.Өвлийн спортын төрлөөр хичээллэх орчинг бүрдүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх. |  |  |                     |                      |   |      |
| 13   | 5.4.1.Тамирчид, хүүхэд багачууд, иргэдийн бэлтгэл сургуулилт хийх чөлөөт цагаа өнгөрүүлэх цанын зам, тэшүүр, хоккейн талбайд мөс тавих;          | Зам талбай байгуулсан байх                                   | 4                   | 6                    | Тайлант онд уулын цанын зам 1, гүйлтийн цанын зам 1, снөүбордын зам 1, хоккейн мөсөн талбай 2, гүйлтийн тэшүүрийн 400м2 тойрог зам 1, шорт трекийн зам 1 нийт 7 зам талбай байгуулж, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх, тэмцээн уралдаан зохион байгуулах, иргэдийг өвлийн спортоор хичээллэхэд зам талбайг байгуулж ажиллалаа. Үүнд: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ өөрийн хөрөнгөөр Сархиа баазад уулын цанын зам, нэмэлтээр снөүбоард, гүйлтийн цанын зам, хоккейн талбай, Орос 19-р сургуулийн хоккейн талбайд мөс тавьсан.<br>-“Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д гүйлтийн тэшүүр, шорт трекийн зам талбайг орон нутгийн төсвийн 60,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулсан. | 100% |
| 14   | 5.4.2.Спорт амралтын хүрээлэнгийн төв асар болон Орос сургуулийн гаднах хоккейн талбайд тамирчдын хувцас солих дулаан өрөө, танхимыг тохижуулах; | Тамирчдын хувцас солих дулаан өрөө танхимыг тохижуулсан байх | 0                   | 2                    | Орос 19-р сургуулийн хоккейн талбайн хувцас солих өрөөний засвар үйлчилгээг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ өөрийн хөрөнгөөр, Спортын өвлийн наадам зохион байгуулахтай холбоотойгоор “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д тамирчдын хувцас солих өрөө, шүүгчдэд дулаан гэр барьж нэмэлт цахилгаан эрчим хүч галлагаа хийж ажилласан. Мөн Сархиа цанын баазад “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Баяжуулах фабрикийн спорт заал, бусад өрөөнүүдийг тамирчдын хувцас солих өрөөгөөр ажиллуулсан.   | 100% |
| 15   | 5.4.3.Тамирчдын бэлтгэл сургуулилт болон хичээлийн хөтөлбөрт ашиглах цана, тэшүүр, хэрэглэл материалаар хангах;                                  | Цана тэшүүрийн хэрэглэл материалаар хангасан байх            | Цана-10<br>Тэшүүр-6 | Цана-90<br>Тэшүүр-86 | - Орон нутгийн төсвийн 2 удаагийн хөрөнгө оруулалтаар уралдааны болон бэлтгэлийн 17 ширхэг цана, 14 ширхэг тэшүүр худалдан авалт хийгдэж 43,0 сая төгрөгийн зарцуулагдсан.Мөн Швейцарийн холбооны улс, Бүгд найрамдах Франц улсын өвлийн спортын үндэсний төвүүдтэй хамтран ажиллах талаар байгуулсан санамж бичгийн хүрээнд спортын төрөлжсөн сургалттай “Ирээдүйн-Одод” сургуульд Швейцарь улсаас 200ш хоккейн тэшүүр, Франц улсаас Хангарьд цанын клубт 13 цана тус тус хандивлагдаж цана, тэшүүрийн тамирчид бэлтгэл сургуулилтаа хийх хэрэглэл материалаар   | 70%  |

|                         |  |  |   |   |   |     |
|-------------------------|--|--|---|---|---|-----|
|                         |  |  |   |   | хангагдлаа.Мөн 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар цас буудагч буу 118,800.0 сая төгрөг, цасны мотоцикль-64,900.0 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус худалдан авалт хийгдэж “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д цанын замыг тавих техник, тоног төхөөрөмжтэй болсон. |     |
| 16                      | 5.4.4.Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын Хангарьд спорт цогцолборын дэргэдэх хоккейн талбайд битүү дээвэртэй мөсөн талбай бүхий ордон байгуулах; | Битүү дээвэртэй мөсөн талбай бүхий ордон байгуулах | 0 | 1 | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Хангарьд хоккейн клубээс битүү дээвэртэй мөсөн талбай бүхий хоккейн барилгын зургийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н зураг төслийн цехээр хийлгэсэн. Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийгдэж байна.  | 40% |
| Биелэлтийн дундаж-92,5% |  |  |   |   |   |     |

Хөтөлбөрийн тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, тус хурлаар 2020-2023 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн биелэлтийг 92,5% буюу хангалттай сайн хэрэгжсэн гэж дүгнэсэн.

Жич:Тус хөтөлбөр нь 2023 он хүртэл хэрэгжиж дууссан тул хяналтнаас хасуулах хүсэлтэй байна.

**“ӨВЛИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРСЭН ТҮВШИН:**

| № | Үндсэн зорилтууд  | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин               | Хүрэх түвшин               |                            |                            | Хүрсэн түвшин  |
|---|---|---|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|--|
|   |   |   | 2019 он                    | 2021 он                    | 2022 он                    | 2023 он                    |  |
| 1 | Орон нутагт өвлийн спортын мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын спорт хариуцсан арга зүйч болон ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багшийг өвлийн спортын төрөл хариуцуулж ажиллуулах, богино хугацааны сургалтаар мэргэшүүлж, чадавхижуулах | Зохион байгуулах сургалт-1 | Зохион байгуулах сургалт-2 | Зохион байгуулах сургалт-3 | Зохион байгуулах сургалт-5 | Өвлийн спортын гүйлтийн цана, уулын цана, хоккейн спортын төрлүүдээр нийт 6 удаагийн сургалтаар 35 биеийн тамирын багш, дасгалжуулагч нарыг сургалтад хамруулсан.  |
| 2 | Өвлийн спортын төрлөөр хичээллэх орчинг бүрдүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх.  | Тамирчид, хүүхэд багачууд, иргэдийн бэлтгэл сургуулилт хийх чөлөөт цагаа өнгөрүүлэх цанын зам, тэшүүр, хоккейн талбай тавих   | 4                          | 4                          | 5                          | 6                          | Нийт 7 зам талбай байгуулсан.<br>-“Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д гүйлтийн тэшүүр, шорт трекийн зам;<br>-Сархиа цанын баазад уулын цана, гүйлтийн цана, снөүбоардын зам, хоккейн талбай;<br>-Хангарьд спорт цогцолборын Орос 19-р сургууль дахь хоккей талбай; |
|   |   | Спорт амралтын хүрээлэнгийн төв асар болон Орос сургуулийн гаднах Хоккейн талбайд тамирчдын хувцас солих дулаан өрөө, танхимыг тохижуулах   | -                          | -                          | 1                          | 1                          | “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д өвлийн улиралд гэр барьж хувцас солих өрөөгөөр ашигласан.<br>Хангарьд спорт цогцолборын Орос 19-р сургууль дахь хоккей талбайн хувцас солих өрөөнд засвар хийгдсэн.  |



|   |   |  |                                     |  |                                       |   |   |
|---|---|--|-------------------------------------|--|---------------------------------------|---|---|
|   |   | Тамирчдын бэлтгэл сургуулилт болон хичээлийн хөтөлбөрт ашиглах цана, тэшүүр, хэрэглэл материалаар хангах                         | Цана-0, Тэшүүр-0                    | Цана-6, Тэшүүр-6   | Цана-12, Тэшүүр-14                    | Цана-90, Тэшүүр-86                                | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон гадаад улсын спортын байгууллагын хандиваар 37ш цана, 214ш тэшүүрээр тус тус хангагдсан.   |
|   |   | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Хангарьд спорт цогцолборын дэргэдэх хоккейн талбайд битүү дээвэртэй мөсөн талбай бүхий ордон байгуулах | -                                   | -  | -                                     | 1   | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Хангарьд хоккейн клубээс битүү дээвэртэй мөсөн талбай бүхий хоккейн барилгын зургийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н зураг төслийн цехээр хийлгэсэн. Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийгдэж байна.  |
| 3 | Өвлийн спорт болон нийтийн биеийн тамирыг нийтэд сурталчлах, чийрэгжүүлэлтийн зөв дадал олгох, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх. | Өвлийн спортын төрлийн спорт холбоод, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх  | Спорт холбоод 2, Хичээллэгч ид 1400 | Спорт холбоо-3 /Цанын холбоо-2, мөсөн шагайн холбоо-1/ Хичээллэгчид 1600 хүн | Спорт холбоо-4, Хичээллэгчид 1800 хүн | Спорт холбоод 4, Хичээллэгчид 20%-иар нэмэгдүүлэх | Аймгийн өвлийн спортын “Ирээдүйн хос мөртөн” цанын холбоо, “Мөсөн сур”, “Мөсөн шагай” “Хоккейн” холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Өвлийн спортын снөүбоард, уулын цана, гүйлтийн цана, тэшүүр, хоккейн спортоор 2500 гаруй иргэд хичээллэж байна. Үүнээс: өвлийн спортын 6 төрлөөр 532 иргэн тамирчид бэлтгэл сургуулилттай тогтмол хийдэг. |
|   |   | Улсын чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах  | 2                                   | -  | -                                     | 4   | -Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг   |

|   |   |   |  |   |   |  |  |
|---|---|---|--|---|---|--|--|
|   |   |   |  |   |   |  | снөүбоард, уулын цана, гүйлтийн цана, гүйлтийн тэшүүр, шорт трек, хоккейн тус бүр 6 төрлөөр аймагтаа амжилттай зохион байгуулсан.  |
|   |   | Тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээн болон нэрэмжит тэмцээнд оролцсон тамирчдын тоо, амжилт нэмэгдсэн байна.           | Тамирчдын тоо 195, Медалийн тоо 69                     | Тамирчдын тоо 15, Медалийн тоо 11                 | Тамирчдын тоо 150, Медалийн тоо 70  | Тамирчдын тоо 210, Медалийн тоо 80   | Тамирчдын тоог 342-оор нэмэгдүүлж, спортын 7 төрлөөр 532 тамирчин тогтмол хичээллэж байна. Үүнээс:<br>-Биатлоны тамирчид-8;<br>-Гүйлтийн цанын тамирчид-60;<br>-Уулын цана, снөүбоардын тамирчид-58;<br>-Мөсний шагайн харвааны тамирчид-165;<br>-Хоккейн-120;<br>-Мөсний сур харвааны тамирчид-121; |
| 4 | Аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцуулах нөхцөл бололцоогоор хангах | Өвлийн спортын төрлүүдээр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах, спортын холбоо, клубтэй хамтран ажиллах | ААШТэмцээн 3 удаа /гүйлтийн цана, хоккей, мөсөн шагай/ | ААШТэмцээн 3 /гүйлтийн цана, тэшүүр, мөсөн шагай/ | ААШТ 6 удаа /биатлон, гүйлтийн цана, уулын цана, тэшүүр, мөсний шагай, мөсний сур харваа/ | ААШТ 8 удаа /биатлон, гүйлтийн цана, тэшүүр, шорт трек, хоккей, мөсний шагай, мөсний сур харваа/ | “Эрдэнэт мөнгөн өвөл-2023” аяны хүрээнд уулын цана, снөүбоард, гүйлтийн тэшүүр, гүйлтийн цана, мөсөн шагай, мөсний сур харвааны 6 төрлөөр тэмцээнийг 2 насны ангиллаар зохион байгуулж 8 аймаг, 5 клубын нийт 350 тамирчин оролцсон.   |

|  |  |  |                      |                     |                     |                       |  |
|--|--|--|----------------------|---------------------|---------------------|-----------------------|--|
|  |  | Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бусад аймаг, сумын баг тамирчидтай хамтарсан бэлтгэлд гаргах, туршлага солилцох уулзалт, нөхөрсөг тэмцээн зохион байгуулах, оролцох | 4                    | 3                   | 3                   | 6                     | Орхон аймгийн гүйлтийн цанын өсвөрийн шигшээ баг, уулын цанын насанд хүрэгчид, өсвөрийн шигшээ баг, хоккейн насанд хүрэгчид, өсвөрийн шигшээ баг, мөсөн сур, мөсний шагай харвааны баг тамирчид Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудад хамтарсан бэлтгэл хийж, тэмцээн уралдаанд оролцсон. |
|  |  | Тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор төрөлжсөн сургалттай спортын дунд сургуульд жил бүр цана, тэшүүрийн тамирчдын элсэлт авна.                                | Цана-15,<br>Тэшүүр-0 | Цана-6,<br>Тэшүүр-0 | Цана-8,<br>Тэшүүр-0 | Цана-30,<br>Тэшүүр-15 | “Ирээдүйн-Одод” дунд сургуульд 6-12 ангийн нийт 7 бүлэгийн 168 сурагчдад тэшүүрээр;<br>Биеийн тамир, спортын газарт гүйлтийн цанын секцэд 40;<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Спорт цогцолборт уулын цанын секцэд 35 өсвөрийн тамирчин тус тус хичээллэж байна.  |